



237

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2004 оны 4 сарын 13 өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

**Дүрэм, хөтөлбөр баталж дэмжлэг
үзүүлэх тухай**

Монгол улсын "Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. "Хөдөлмөр, хүмүүжил-сургалтын төв"–д зохион байгуулалтын өөрчлөлт хийж "Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төв" болгон орон тооны дээд хязгаарыг 45 байхаар тогтоосугай.

Хоёр. "Хөдөлмөр, хүмүүжил сургалтын төвийн зохион байгуулалтанд өөрчлөлт орсонтой холбогдуулан Ц.Нарандэлгэрийг 2004 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөр тасалбар болгон Хөдөлмөр, хүмүүжил сургалтын төвийн захирлын үүрэгт ажлаас чөлөөлж, мөн өдрөөс эхлэн "Хүүхдийн сургалт, хүмүүжлийн тусгай төв"-ийн захирлаар томилж, сарын үндсэн цалинг 75800 төгрөгөөр, ур чадварын нэмэгдлийг 20 хувиар нэмэгдүүлэхийг тус төвийн нягтлан бодогч Г.Уранчимэгт зөвшөөрсүгэй.

Гурав. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхдийн сургалт, хүмүүжлийн тусгай төвийн дүрмийг 1 дүгээр, зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, хөтөлбөрийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

Дөрөв. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан, ажлын шаардлагыг харгалзан ажилчин, албан хаагчдыг томилж чөлөөлөн цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоохыг Хүүхдийн сургалт, хүмүүжлийн тусгай төвийн захирал /Ц.Нарандэлгэр/-т үүрэг болгосугай.

Тав. Хүүхдийн сургалт, хүмүүжлийн тусгай төвийг Засгийн газрын 1999 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан "Тусгай сургалтын төрийн өмчийн байгууллагын зарим ажилтанд нэмэгдэл хөлс олгох тухай журам"-д хамааруулсугай.

My dok. Zakiramji-01

0200497

Зургаа. Дэлхийн банкны төсөлд хамруулах замаар хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төвийн байранд хэсэгчилсэн засвар хийж, үйл ажиллагаанд нь зайлшгүй шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгслэлээр хангах арга хэмжээ авахыг Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс /Ш.Наран/-т даалгасгай.

Долоо. Энэ захирамж гарсантай холбогдуулан 1999 оны А/214 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД